

**ДОРНОД**  
**АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ**  
**БОДЛОГО**

**(2009 – 2016 он)**

**2009 он.**

## ГАРЧИГ

Хуудас

ОРШИЛ.....	
Нэг. Дорнод аймгийн хөгжлийн өнөөгийн байдал, хөгжлийн давуу болон сул талууд	
1.1 Дорнод аймгийн хөгжлийн өнөөгийн байдал.....	3-7
1.2 Дорнод аймгийн хөгжлийн давуу болон сул талууд.....	7-8
Хоёр. Дорнод аймгийн хөгжлийн алсын хараа, тэргүүлэх чиглэлүүд.....	8-9
• Дорнод аймгийн хөгжлийн алсын хараа.....	8
• Дорнод аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд.....	9
2.1 Хүнээ бүх талаар хөгжүүлэх.....	9-11.
2.2 Үйлдвэржүүлэлт.....	11-17
2.3 Дэд бүтцийн хөгжил.....	17-19
2.4 Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотыг хөгжүүлэх.....	20-22
2.5 Гадаад харилцааг хөгжүүлэх .....	22-24
2.6 Аялал жуулчлал хөгжүүлэх .....	24-25
Гурав. Дорнод аймгийн нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтүүд .....	25-27
Дөрөв. Хүрэх гол үр дүн, хэрэгжилтийг хангах механизм.....	27-28
4.1 Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн.....	
4.2 Цогц бодлогын хэрэгжилтийг хангах механизм.....	
Хавсралт 1. Дорнод аймгийн сумдыг 2009-2016 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө	

## НЭГ. ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД

### 1.1 Дорнод аймгийн нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал

Дорнод аймагт 2008 оны байдлаар улсын нийт хүн амын 2.7 хувь, Зүүн бүсийн хүн амын 36.9 хувь буюу 74.5 мянган хүн оршин сууж байна. Чойбалсан хотод 968 хүүхэд төрсөн байхад хөдөөд 801 хүүхэд төржээ. Иймд Зүүн бүсийн 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлтийн хэмжээг аймгийн үзүүлэлттэй харьцуулж үзвэл, төрөлт 23.5, байхад аймагт 24.2, нас баралт 6.4 байхад аймагт 6.3, цэвэр өсөлт 17.1 байхад аймагт 17.8 байна. Хүн амын дундаж наслалт улсын хэмжээнд 67 жил байхад Дорнод аймагт 63 жил байна.

Аймгийн нийт хүн амын 30.8 хувь буюу 22982 хүн эдийн засгийн идэвхитэй хүн ам байгаа бол Зүүн бүсэд хөдөлмөр эрхэлж буй 71400 хүн байгаагийн 30.9 хувь нь буюу 22089 хүн нь манай аймагт ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 917 хүн ажилгүй гэж бүртгэгдсэний 74.3 хувь нь буюу 681 нь эмэгтэйчүүд байна. Мөн 2008 оны байдлаар аймагт 19886 өрх амьдарч байгаагийн 11.7 хувийг эмэгтэйчүүд толгойлж байна. Ажилгүйдлийн түвшний улсын дундаж 2005 онд 3.3 байсан бол 2008 онд 2.8 болж буурсан байхад манай аймагт 2005 онд 5.0 байсан бол 2008 онд 4.0 болж буурсан нь улсын дундажаас 1.2-оор их байна. Зүүн бүсэд ажилгүйдлийн түвшин 3.6 байхад аймагт 4.0 байгаа нь харьцангуй өндөр байгаа юм. Аймгийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч ядуурал дорвитой буурахгүй байна. Ядуу өрхийн дийлэнх нь аймгийн болон сумын төвд амьдарч байна.

Ажилгүйдэл, ядуурлыг багасгахад аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Боловсрол, соёл** Тус аймагт 2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 26 сургуульд 13008 сурагч суралцаж байна. Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүх шатны сургуулиудын сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай байна. Мөн соёл урлагийн байгууллагуудын урын санг баяжуулах музей, Хөгжимт драмын театр, номын санг төрөлжсөн эрдэм судлалын ажлын орон тооны бус судлаачдын багаар бүрдүүлэх, иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний чанарыг шаардлагын хэмжээнд хүргэх, соёлын өв тээгчдийг сурталчлах, өвлөн авах, ЕБС-ийг түшиглэн ардын уламжлалт урлагийн сургалтуудыг нээж хичээллүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалах, хамгаалах ажлыг цогцоор шийдвэрлэх шаардлагатай юм.

**Эрүүл мэнд** Аймгийн эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангалт, мэргэжлийн ур чадварын түвшин харилцан адилгүй, эмнэлгүүдийн төсөв материаллаг баазын хангамж, хүрэлцээ хангалтгүйгээс эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрээгүй байна.

**2) Эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал.** 2007 оны байдлаар Дорнод аймгийн ДНБ оны үнээр 61.7 тэрбум.төг байсан бол 2008 онд 79.9 тэрбум.төг болж өмнөх онынхоос 29.6 хувиар өсчээ. Дорнод аймаг нь Монгол Улсын ДНБ-ний 1.3 хувийг, Зүүн бүсийн ДНБ-ний 23.9 хувийг тус тус үйлдвэрлэж байна

Дорнод аймгийн нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 2007 онд 1376.8 мян.төг байсан бол 2008 онд 1676.3 мян.төг болж 21.8 хувиар өсчээ. Энэ нь улсын дүнгээс 2.0 дахин, Улаанбаатараас 2.5 дахин бага байгаа бол бүсийн дунджаас 35.2 хувиар бага байна.

Дорнод аймгийн ДНБ-д салбаруудын эзлэх хувийг авч үзвэл, 2007 оны байдлаар хөдөө аж ахуй 50.7 хувийг, аж үйлдвэр, барилга 22.9 хувийг, үйлчилгээний салбар 26.5 хувийг тус тус эзэлж байсан бол 2008 онд хөдөө аж ахуй 47.3, аж үйлдвэр, барилга 22.4, үйлчилгээний салбар 30.3 хувийг эзэлж байна. Тус аймаг 2008 оны байдлаар улсын нийт хөдөө аж ахуйн салбарын 3.3 хувийг, аж үйлдвэр барилгын салбарын 0.8 хувийг, үйлчилгээний салбарын 0.9 хувийг эзэлж байна.

Дорнод аймгийн ДНБ-ний салбарын бүтцийг улсын болон Төвийн бүс, бусад аймгуудтай харьцуулбал эдийн засгийн салбарын бүтцэд хөдөө аж ахуйн салбар ихэнхи хувийг эзэлж ,ХАА, үйлчилгээний салбар илүү давамгайлж байна.

Дорнод аймгийн төсвийн орлого 2008 онд 2955.4 сая.төг болж өмнөх оныхоос 52.4 хувиар, төсвийн зарлага 4193.3 сая.төг болж өмнөх оныхоос 58.3 хувиар өсчээ.

Цаашид “Дорнод” үйлдвэрлэл технологийн паркийг байгуулж ашигт малтмал олборлох, боловсруулах, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, сүү, цагаан идээ боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэрийн салбарт өндөр өсөлтийг бий болгох, бэлчээрийн мал аж ахуйгаас эрчимжсэн фермерийн аж ахуй, усалгаатай газар тариаланг эрчимтэй хөгжүүлэх чиглэлийг баримтлах шаардлагатай.

**Аж үйлдвэр. Чойбалсан** хот нь Улаанбаатар, Эрдэнэт, Дарханы дараа орох том хот, аж үйлдвэрийн томоохон төв бөгөөд “Дорнод гурил”, “Адуунчулуун”, “ДБЭХС” ХК, “Мах маркет”, “Онхоодой”, “Найнги” зэрэг үйлдвэрийн газрууд, “Петрочайна Дачин Тамсаг Монгол”, “Шинь шинь”, Шан лун” “ Эмээлт Майнзи”, “Төв Азийн уран” “Талын жигүүр” “Жараахайн булаг” зэрэг уул уурхай, барилгын материалын томоохон компаниуд байна.

<http://gate1.pmis.gov.mn/darkhan-uul/image/darkhan4-1.jpg> Дорнод аймагт жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, хувийн хөрөнгө оруулалттай оёдол, архины үйлдвэр, талх нарийн боов, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрүүд, банк, аж ахуйн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Дорнод аймгийн аж үйлдвэрийн борлуулалтын орлого 2008 оны байдлаар 13.9 тэрбум.төг болсон нь өмнөх оныхоос 79.3 хувиар өсч, Зүүн бүсийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалтын 3.8 хувь, улсын 0.2 хувийг эзэлж байна .

Дорнод аймаг нь цайр, холимог металл, газрын тос, уран, нүүрс, барилгын үйлдвэрлэлд тохиромжтой төрөл бүрийн түүхий эд, эрдэс материалын арвин нөөцтэй нутаг юм.

**Үйлчилгээний салбар.** Дорнод аймгийн ДНБ-ний 30.3 хувийг үйлчилгээний салбарт үйлдвэрлэж байна. Сүүлийн жилүүдэд бөөний болон жижиглэн худалдаа, гэр

ахуйн барааны засварлах үйлчилгээ, тээвэр, холбоо, санхүүгийн гүйлгээ,, бизнесийн үйл ажиллганы салбарт өсөлт гарч байна.

Үйлчилгээний салбар өргөжин хөгжиж байгаа хэдий ч үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрээгүй, үйлчилгээний үнэ өндөр хэвээр байна. Мөн үйлчилгээний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажиллах орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр их зүйл хийх шаардлагатай байна.

**Хөдөө аж ахуй.** Аймгийн хэмжээнд 2008 оны байдлаар 4719 малчин өрхийн 9793 малчид амьдарч байна. Малын тоо толгой 2008 оны эцсийн байдлаар 1476.2 мянган мал тоологдож өмнөх оныхоос 12.9 хувиар өсчээ. Мал сүргийн бүтцийг авч үзвэл тэмээ 0.4 хувь, адуу 9.9 хувь, үхэр 8.4 хувь, хонь 46.6 хувь, ямаа 34.7 хувийг тус тус эзэлж байна. Одоогийн байдлаар тус аймагт 11 үүлдэр, омог, хэвшлийн 40.6 мянган толгой цэвэр болон эрлийз мал, нутгийн шилмэл омгийг өсгөн малын үржлийн сайжруулагчаар ашиглаж байгаа нь нийт малын 2.7 орчим хувийг эзэлж байна.

Дорнод аймаг 2008 онд 2.8 мян.га газар тариалалт хийснээс 2.4 мян.га-д үр тариа, 0.3 мян.га-д төмс, 0.1 мян.га-д хүнсний ногоо тариалжээ. Үүнээс үр тариа 3.0 мян.тн, хүнсний ногоо 0.8 мян.тн, 1.8 мян.тн төмс хураан авч, 56.5 мян.тн малын тэжээл, 55.3 мян.тн байгалийн хадлан бэлтгэжээ.

Тус аймаг нь хүн амын мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээг 100 хувь, гурилын 90.0 гаруй хувийг, сүү сүүн бүтээгдэхүүний хэрэгцээний 70.0 орчим, төмс, хүнсний ногооны хэрэгцээний 50-60 хувийг өөрийн үйлдвэрлэлээр бүрэн хангаж байна.

Аймгийн төвийн ойролцоох бэлчээрийн даац хэтэрч ургамалжилт хэт багасчээ. Малчдын хөдөлмөр зохион байгуулалтын оновчтой хэлбэр болох хоршоо, фермерийн аж ахуйг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж байгаа ч түүний хэрэгжилтийн явц удаан, малчдын хөрөнгө хүч, хөдөлмөр тархай, аж ахуйг удирдах арга барил дутагдалтай хэвээр байна. Мал аж ахуйд үржлийн ажлыг гардан хэрэгжүүлэх мэргэжлийн үйлчилгээ дутагдаж, малчид малын чанар үржлийн ажлын үр нөлөөг дутуу үнэлэх болсон нь малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

**Дэд бүтэц. Эрчим хүч.** Дорнод аймаг дэд бүтэц сайн хөгжсөн аймаг бөгөөд дулаан, цахилгааны эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй. Чойбалсан хот дахь 36 мВт-ын хүчин чадалтай Дулааны цахилгаан станц жилдээ 130 сая кВт цахилгаан, 550 мян гКал дулаан үйлдвэрлэдэг, өнөөдөр хүчин чадлынхаа 40 гаруй хувийг ашиглаж байна. Манай аймгийн 11 сум төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон, 1 суманд /Матад/ сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж суурилуулсан, 2 сум /Чулуунхороот, Халхгол сум/ ОХУ, БНХАУ-аас эрчим хүч импортлон авч байна.Чойбалсан хот нь төвлөрсөн ус, дулааны хангамжтай. Цахилгаан хэрэглээний 24.1 хувийг айл өрх, 68.1 хувийг үйлдвэр, аж ахуйн нэгж, 7.8 хувийг үйлчилгээний газрууд хэрэглэж байна. Мөн тус аймаг жилдээ 600.0 мян.тн нүүрс гаргах хүчин чадалтай Адуунчулууны ил уурхай нь “ДБЭХС” ХХК-ийг нүүрсээр хангаж байна.

**Зам тээвэр.** ОХУ-тай төмөр замаар холбогдсон. Дотоодын тээвэрт 370 орчим км төмөр зам ашиглагдаж байна. Энэ замаар Ази, Европын орнуудтай шууд холбогддог бөгөөд цаашдаа “Түмэн гол” төслийн хүрээнд Баянтүмэнгийн төмөр замыг БНХАУ-ын Рашаантын чиглэлд 450 гаруй км зам тавьж холбох төслийн урьдчилсан судалгааг Шведийн зөвлөх сангийн санхүүжилтээр хийгээд байгаа ба БНХАУ-ын Засгийн газрын

дэмжлэгтэйгээр Бичигт-Баруун-Урт-Чойбалсангийн чиглэлийн төмөр зам барих ажлын техник эдийн засгийн үнэлгээг хийж байна.

Авто замын хувьд аймгийн төв, хот хооронд авто тээврийн үйлчилгээг Тээвэр зохицуулалтын алба эрхлэн зохион байгуулж, хот дотор нийтийн тээвэрт 7 чиглэлд 20 микроавтобус иргэдэд үйлчилж байна. Таксины үйлчилгээг хувийн жижиг машинтай иргэд үзүүлдэг.

Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр Чойбалсан хотын онгоцны буудлыг Буянт-Ухаангийн олон улсын онгоцны буудлын нөөц буудал болгон өргөтгөл хийж, 2001 онд ашиглалтад оруулж, онгоц хөөрч буух 2,8 км урт 40 м өргөн өндөр даацын бетон зурвас бүхий нийтдээ 112000 м<sup>2</sup> талбайтай бөгөөд ОХУ-ын АН-30, ТУ-154, ИЛ-86, АНУ-ын Боинг-727, С-130 зэрэг томоохон онгоцууд буух, гадаадын жуулчдыг Улаанбаатар хотоор дамжуулалгүй шууд Дорнод аймагт хүлээн авах боломжтой юм. 2009 оноос Чойбалсан-Хайлаарын чиглэлийн олон улсын агаарын шинэ зам нээгдэх болоод байна.

**Харилцаа холбоо:** Улаанбаатар хоттой өндөр хурдны шилэн кабель, интернет, утсан ба үүрэн телефонны үйлчилгээ бүрэн нэвтэрсэн, аймгийн төв бүх сумдад орчин үеийн техник технологиор бүрэн тоноглогдсон Мобиком, Скайтел, Миком, Жи-Мобайл, Юнител компаниудын салбарууд үүрэн телефон, интернетийн үйлчилгээ явуулж байна. “Цахилгаан холбоо”, “Цацраг трейд” компаниудын кабелийн телевизүүдээр 24 цагийн турш гадаад дотоодын сувгуудын нэвтрүүлгүүдийг үзэх боломжоор хангагдсан.

**Аялал жуулчлал:** Дорнод аймаг 123,5 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, газарзүйн байршлын хувьд хойд талаараа ОХУ-лс, зүүн, зүүн өмнөд талаараа БНХАУ-тай, баруун, баруун урд талаараа Сүхбаатар, баруун талаараа Хэнтий аймагтай хиллэдэг, Ази номхон далайн орнуудад хамгийн ойр дэд бүтэц, зам тээврийн хувьд харьцангуй сайн аймаг юм. Чойбалсан хот Улаанбаатар хотоос 665 км алслагдсан, далайн түвшнээс дээш 700 метрт оршдог.

Хөрш зэргэлдээ ОХУ-тай Ульхан Майхан-Верхний Ульхан, Эрээнцав-Соловьёвск, БНХАУ-тай Хавирга-Архашаат, Баянхошуу-Өвдөг, Сүмбэр-Рашаант зэрэг боомтоор улирлын болон байнгын үйл ажиллагаатай хилийн боомттой учир хил орчмын аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.

Дорнодын уудам тал бол байгалийн үзэсгэлэн бүрдсэн экологийн хувьд унаган төрхөөрөө хадгалагдаж үлдсэн, талын экосистем бүхий дэлхийд цөөхөн газар нутгийн нэг юм.

Дорнод аймгийн түүх, соёлын дурсгалт газрууд одоог хүртэл бүрэн төгс хадгалагдсаар ирсэн нь аялал жуулчлалын нөөц болж байгаа юм.

Цагаан-Овоо сумын нутагт Хэрлэн голын хойд эрэгт орших 11-р зууны Киданы үеийн Хэрлэн бар хотын туурь, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Гурванзагал сумын нутгаар үргэлжлэх Чингисийн Хэрмэн зам, Халхгол сумаас хойш 35 км-т орших 1859-1964 онд бүтээсэн Их Бурхантын цогцолбор, Шонх таван толгой дахь түрэгийн үеийн хүн чулуу, Матад сумын Хийморийн говь, Наран, Сэргэлэн сумын Хөцөө гэдэг газар байдаг хүн чулуу, эрх чөлөөны төлөө тэмцэгч Гүн Саваагийн балгас, Халхгол сумын нутаг Тамсагбулаг гэдэг газар байдаг Илдэн вангийн хошууны Тогтохтер вангийн бүтээсэн хиймэл уул Утай 5 уул, “Монголын нууц товчоо” номонд бичигдсэн Мэлхий буюу гэр хад зэрэг түүх, соёлын дурсгалт газрууд бий.

Аймгийн төвд уран зургийн галарей, түүх угсаатны, байгалийн, Дайчин алдрын “Ялалт”, ЗХУ-ын маршал Г.К.Жуковын, сумдад орон нутгийг судлах музейнүүд ажилладаг.

Аймагт эрүүл ахуйн стандартын нөхцөл шаардлага хангасан нэг ээлжиндээ 5-120 хүн хүлээн авах хүчин чадалтай 20 гаруй зочид буудал, 5 ресторан, 20 бар, 18 кафе, 30 гаруй цайны газар ажилладаг.

Тус аймгийн төвд нийт 9 зочид буудал, 9 дэн буудал үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нэг ээлжинд нийт 153 өрөөнд 281 хүн хүлээн авах хүчин чадалтай, ресторан, 50-150 хүний хурлын танхим, интернет, бизнес үйлчилгээ үзүүлэх төв, саун массаж, гоо сайхны үйлчилгээ, караоке, билльярд, фитнес заал зэрэг зочдын амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх чиглэлээр нэмэлт үйлчилгээ үзүүлж байна. Аймгийн төвийн ойролцоо “Энх”, “Дөлгөөн Хэрлэн”, “Шаазан нуур”, Халхгол суманд “Буйр”, Баян-Уул суманд “Хархираа”, Дашбалбар суманд “Чух”, Баяндун суманд “Угтам” Цагаан – Овоо сумын “Гүн цэнгэлэг” зэрэг нэг ээлжиндээ 5-30 хүн хүлээн авах хүчин чадалтай амралт болон жуулчны гэр баазтай.

Аймгийн төв болон бүх сумдад ХААН, Монгол шуудан банк, Чойбалсан хотод Хас, Зоос, Голомт, Худалдаа хөгжлийн банкууд үйл ажиллагаагаа явуулдаг ба олон улсын хооронд мөнгө гуйвуулах MONEYGRAMM, WESTERN UNION үйлчилгээ үзүүлдэг.

**3) Гадаад харилцаа:** Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, Гадаад бодлогын үзэл баримтлалын дагуу аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хилийн таван боомттой газар зүйн байршлын давуу талаа ашиглаж, хөрш зэргэлдээ орших ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот, Хянган, Шилийн гол аймагтай нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Цаашид гадаад харилцааг тэргүүлэх чиглэлийн нэг болгон Зүүн хойд Ази, Европын өндөр хөгжилтэй орнуудын аймаг, мужтай харилцаа тогтоож, гадаад харилцааг эдийн засагжуулах бодлогын хүрээнд гадаад хамтын ажиллагааны үр ашгийг экспорт импортыг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, туршлага нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгох зэрэг эдийн засгийн хөгжилд түлхүү чиглүүлэх шаардлагатай байна.

## **1.2 Дорнод аймгийн хөгжлийн давуу болон сул талууд**

Дорнод аймгийн 2009-2016 он хүртэл хөгжүүлэх цогц бодлогод хөгжлийн дор дурьдсан давуу болон сул талуудыг тооцон үзэв. Үүнд:

### **Хөгжлийн давуу талууд:**

- Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин өндөр;
- Боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд өрсөлдөхөд ашиглаж болох газрын тос, холимог металл, уран, нүүрс, давс, алт зэрэг түүхий эдийн баялаг нөөцтэй.
- Эрдэс түүхий эдийн нөөцөнд тулгуурласан хүнд үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрүүдийг өргөжүүлэн хөгжүүлэх боломжтой;
- Төмөр зам, агаарын тээвэр, холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтэц хурдан хөгжих нөхцлөөр харьцангуй сайн
- Хил залгаа орших ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар нутаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хянган, Шилийн гол аймагтай гадаад харилцааг хөгжүүлэх, тэдний зах зээлийн багтаамжийг ашиглах газар зүйн тааламжтай байршил,
- Зүүн хойд Азийн эдийн засгийн бүс нутагт татагдан хөгжих ирээдүйн боломж,

- Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, хил орчмын аялал жуулчлал хөгжүүлэх нөхцөл боломж,
- Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэхэд ашиглаж болох барилга байгууламжийн багагүй нөөц
- Хадлан бэлчээр, тариалангийн зориулалтаар ашиглаж болох хөдөө аж ахуйн эдэлбэр газрын харьцангуй их нөөц

### **Сул талууд**

- 1/ Төвлөрлийг сааруулж, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, төсвийн орлогын тодорхой хэсгийг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад ашиглах эрх хязгаарлагдмал
- 2/ Хүн ам аймгийн төвд хэт төвлөрсөн, 1 м квт ногдох хүний тоогоор сийрэг
- 3/ Ажилгүйдэл, ядуурлын түвшингээр бусад аймгуудаас харьцангуй өндөр
- 4/ Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшин доогуур, дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл бага,
- 5/ Ган цөлжилтөд хялбархан нэрвэгдэж болох нөхөн сэргээгдэх чадвар султай экологийн эмзэг орчинтой
- 6/ Санхүү, хөрөнгө оруулалтын эх үүсвэр хязгаарлагдмал
- 7/ Хаврын улиралд салхи шуурга ихтэй, ой хээрийн түймрийн гамшигт өртөмтгий
- 8/ Халдварт өвчнөөр өвчлөгсөд, нялхсын эндэгдэл, нас баралтын түвшин харьцангуй өндөр
- 9/ Нийслэл Улаанбаатар хотоос алслагдмал, хатуу хучилттай авто замаар холбогдоогүй
- 10/ МАА, газар тариалангийн үйлдвэрлэл байгаль, цаг агаарын байдлаас ихээхэн хамааралтай;
- 11/ Хөрсний элэгдэл, бэлчээрийн доройтол их, байгалийн нөхөн сэргээгдэх нөөц багатай зэрэг болно.

## **ХОЁР. ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД**

### **Дорнод аймгийн хөгжлийн алсын хараа**

Дорнод аймгийн хөгжлийн 2021 он хүртлэх АЛСЫН ХАРАА нь хүний хөгжилд тулгуурлан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлэн, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, Монгол Улсын зүүн бүсийн хөгжлийн татах хүч, эдийн засгийн төв байхад оршино.

### **Дорнод аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд**

***Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлогыг дараах зургаан тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ:***

- 1) Хүнээ бүх талаар хөгжүүлэх
- 2) Үйлдвэржүүлэлт

- 3)Дэд бүтцийн хөгжил.
- 4)Бүсийн тулгуур төв Чойбалсан хотыг хөгжүүлэх.
- 5)Гадаад харилцааг хөгжүүлэх
- 6)Аялал жуулчлал хөгжүүлэх

## 2.1 ХҮНЭЭ БҮХ ТАЛААР ХӨГЖҮҮЛЭХ

***Дорнод аймгийн хөгжлийн 1 дэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2008 онд боловсруулсан аймгийн Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.***

Аймгийн хэмжээнд хүнээ бүх талаар хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын түвшинг дээшлүүлэх замаар хүний хөгжлийн индексийг 0830-д хүргэнэ.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогоор өрх гэрийг дэмжин тэтгэж, нийгмийн суурь үйлчилгээг /эрүүл мэнд, бололсрол, ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлт/ бүрэн хүргэснээр хүний хөгжлийг бүх талаар хангана.

- а/ Хүнийг өөрийг нь хөгжүүлэх
  - Эрдэм боловсрол олгох
  - Бие бялдрыг эрүүл чийрэг хөгжүүлэх
  - Хүнээ нийгэмшүүлэх
- б/ Хүний амьдрах ая тухтай орчинг бий болгох

***Стратегийн зорилт 1. Аймгийн хэмжээнд мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж , амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 2000 онтой харьцуулахад 2016 онд 2 дахин бууруулах***

- “Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил” аймгийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Аймаг, сумдын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлэх;
- Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Хүн амын ахуйн хэрэглээний хангамжийг нэмэгдүүлнэ.

**Стратегийн зорилт 2. Бүх хүүхдэд анхан шатны боловсрол олгох**

- Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн талаар хөтөлбөр боловсруулан иргэд олон нийтийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;
- СӨБ-ийн сургалтын орчинг сайжруулан, материаллаг баазыг бэхжүүлж, хамран сургалтыг 90 хувьд хүргэн, улсын хэмжээний загвар сургалтын төв байгуулах,
- ЕБС-д суралцагчдын хүйсийн тэгш бус байдлыг арилгах;
- Сургууль бүрийг хямд өртөгтэй, найдвартай ажиллагаа бүхий интернет номын сантай болгож, хүүхэд бүрт компьютер хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

- Сумдын сургуулиудын дотуур байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх;
- Сургалтанд мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэн, бүх сургууль цэцэрлэгүүдийг интернетэд холбож, мэдээллийн технологийн техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах;
- Шаталсан сургалттай техник технологийн сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн уул уурхай, жижиг дунд үйлдвэрийн чиглэлээр мэргэжилтнүүдийг бэлтгэх;
  - Их, дээд сургуультай хоршсон шинжилгээ судалгааны төрөлжсөн байгууллага, салбар, мэдээллийн технологийн төвүүд байгуулж ажиллуулахыг урамшуулан дэмжих;
  - Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг “Дорнод” дээд сургуулийг түшиглэн зохион байгуулах боломжийг хангах, Багшийн хөгжлийн төв байгуулах,
    - Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ;
- Дорнод дээд сургуулийг Дорнод монголын их сургууль болгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- Үндэсний уламжлалт болон сонгодог урлаг, хүүхдэд зориулсан урлагийн төрлийг төрөөс дэмжих Засгийн газрын үндэсний хөтөлбөр, төслүүдийг орон нутагтаа хэрэгжүүлэх, олон нийтийн хүртээл болгон дэлгэрүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааг орон нутгийн бодлогоор дэмжих.
- Аймгийн соёл урлагийг 2009-2016 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;
- Аймгийн музейг “ Дорнын тал түүх, соёлын цогцолбор” болгон хөгжүүлж, сургалт, судалгааны төв болгон өргөжүүлнэ.

**Стратегийн зорилт 3. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах орчин үеийн тогтолцоог цогц байдлаар бүрдүүлнэ:**

Аймгийн хүн амын өвчлөлийн байдлыг тогтоох судалгаа явуулж, эрүүл мэндийн байдлыг хянан тандаж мэдээлэх, ард иргэдийг жилд нэг удаа үнэ төлбөргүй үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах тогтолцоо бүрдүүлэх;

- Эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн цахим сүлжээнд оруулан нэгдсэн мэдээллийн цахим сантай болгож, алсын зайн оношлогоо, эмчилгээг өргөжүүлэх;
- Халдварт өвчин, нялхсын эндэгдлийг бууруулна;
- Уламжлалт анагаах ухааны шилдэг аргыг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэх
  - Аймгийн хүн амын дархлаажуулалтыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
  - Бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
    - Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тууштай сайжруулах замаар 2016 он гэхэд хүн амын дундаж наслалтыг 68-д хүргэх;

**2.2 ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТ**

**Дорнод аймгийн үйлдвэржүүлэлтийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2009-2016 онд хүнд, хөнгөн үйлдвэр, барилгын материалын, хүнсний болон жижиг дунд үйлдвэрүүдийг өргөжүүлэх буюу шинээр байгуулах замаар иргэдээ ажлын байраар хангаж, экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн суурийг тавина.**

Стратеги зорилт 1. Бэлчээрийн болон эрчимжсэн МАА-г хослуулан хөгжүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан ХАА-н үйлдвэрлэлийг жилд дунджаар 10.6 хувиар өсгөнө.

а/ ХАА-н үйлдвэрлэлийн чиглэлээр

д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх сум, байгууллага	Хугацаа
1	Аймгийн “Хөдөө аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах” хөтөлбөр, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих”, “Сүү”, “Бруцеллөз” дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн амжилттай хэрэгжүүлэх;	Аймгийн ХХААЖДҮГ	2009-2016
2	Сүүний болон махны чиглэлийн үхрийн аж ахуй, ноос-махны хонины аж ахуй, гахайн аж ахуй, зөгийн аж ахуй,	Халхгол, Баян-Уул, Цагаан –Овоо, Булган, Хөлөнбуйр, Баянтүмэн СэргэлэнЧулуунхороот	2009-2016
3	Мах-ноосны хонины аж ахуй,	Дашбалбар, Сэргэлэн	2009-2016
4	Сүү болон махны үхрийн аж ахуй, махны чиглэлийн хонины аж ахуй	Гурванзагал, Чойбалсан, Хэрлэн, Матад	2009-2016
5	Үүлдэр, омог, гойд ашиг шимт малын үржлийн биологийн лаборатори байгуулах;	Аймгийн ХХААЖДҮГ	2009-2016
6	Аймгийн “Мал үржлийн селекцийн төлөвлөлт”-ийг боловсруулан мөрдөж <b>үхрийн</b> аж ахуйд симменталь, хар тарлан, Алатау, Казакын цагаан толгойт,Лимузин	Аймгийн ХХААЖДҮГ	2009-2016
7	<b>Хонины</b> аж ахуйд Барга, Үзэмчин, Өвөр байгаль үүлдрийн нарийн ноост хонийг үржүүлэх,	Аймгийн ХХААЖДҮГ	2009-2016

8	Ямааны аж ахуйд Баяндэлгэрийн хэвшлийн улаан ямаа, Тулман хөхт үндсэн сайжруулагчаар ашиглах;	Аймгийн ХХААЖДҮГ	2009-2016
9	Тэжээвэр амьтдын аж ахуйг боловсруулах үйлдвэрийн хамт хөгжүүлэх	Аймгийн ХХААЖДҮГ Бүх сумд	2009-2016
10	Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах;	Сумдын ЗДТГ	2009-2016
11	Жил бүр тэргүүний малчдын зөвлөлгөөнийг төрөлжүүлэн явуулж ажлын арга туршлага солилцох, суралцах, өндөр ашиг шимт мал олж авах, үржлийн шилмэл малаа сурталчилах зэрэг арга хэмжээ зохион байгуулах;	Аймгийн ХХААЖДҮГ Бүх сумд	2009-2016
12	Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг худаг, уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд урт хугацаанд гэрээгээр эзэмшүүлэх	Бүх сумд	2009-2016
13	Аймгийн “Атрын III аян”, “Ногоон хувьсгал” дэд хөтөлбөр, “Жимс жимсгэнэ” хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх нөхцлүүдийг бүрдүүлэх;	Баяндун Халхгол Хөлөнбуйр Хэрлэн	2009-2016
14	Үр тарианы үндсэн үйлдвэрлэл, сортын буудай, төмсний үр үйлдвэрлэл, таримал тэжээлийн үйлдвэрлэл, хадлан бэлтгэл,	Халхгол, Чойбалсан	2009-2016
15	Төмс хүнсний ногооны үрийн төмс хүнсний ногооны үйлдвэрлэл, далд болон хамгаалагдсан хөрсний ногооны дагнасан аж ахуй, зоорь, агуулахын аж ахуй үйлдвэрлэл	Хэрлэн, Баяндун, Баянтүмэн	2009-2016
16	Өрхийн тариалан	Бүх сумд	2009-2016

17	<ul style="list-style-type: none"> <li>• Үрийн болон хүлэмж, жимс, жимсгэний аж ахуйг бодлого төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх;</li> </ul>	Хэрлэн Баяндун, Баян-Уул	2009-2016
18	<ul style="list-style-type: none"> <li>• Чойбалсан хотод механикжсан хөргүүртэй, өндөр хүчин чадалтай хүнсний ногооны агуулах барих;</li> </ul>	Хэрлэн	2011-2014
19	<ul style="list-style-type: none"> <li>• Аймагт “Хөдөө аж ахуйн техникийн засвар үйлчилгээний төв”-ийг олон улсын байгууллагын болон төсвийн хөрөнгөөр байгуулан ажиллуулах;</li> <li>• Сумдын Агропаркуудыг бэхжүүлэн, үйл ажиллагааг нь тогтмолжуулах</li> </ul>	Хэрлэн Бүх сумд	2011-2013
20	<ul style="list-style-type: none"> <li>• Мал аж ахуй, газар тариаланг хослон эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид бага оврын трактор, цахилгаан үүсгүүр, хадлангийн болон газар тариалангийн техник хэрэгслийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх;</li> </ul>	Аймгийн ХХААЖДҮГ Бүх сумд	2010-2016
21	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Шаталсан сургалттай техник, технологийн сургуультай хамтран сумдын захиалгыг харгалзан нэгдсэн бодлого зохицуулалттайгаар мэргэжилтэй ногоочид, тракторч-фермерийн ангийг байгуулж, түүнд суралцах хүүхдийн тоог нэмэгдүүлж, давтан сургах, сургалт дамжаа зохион байгуулах;</li> <li>• Аймгийн хэмжээнд байгаа агрономич, механикжуулагч мэргэжилтнүүдийг давтан сургалтад хамруулах, шинээр боловсон хүчин бэлтгэх;</li> <li>• Хөрсний үржил шимийг дээшлүүлэх нөхөн сэргээх зорилгоор Улз гол хоршооны биобордооны үйлдвэрлэлийг дэмжих, байгальд ээлтэй экологижсон технологи нэвтрүүлэх;</li> <li>• Багсармал, холимог, хорголжин болон бичил язгуур махбодын бүрэн найрлагат эрдсийн тэжээлийн үйлдвэр байгуулж, төрөл бүрийн тэжээл үйлдвэрлэж байсан уламжлалыг тусгайлсан бодлогоор сэргээх;</li> </ul>	Аймгийн ХХААЖДҮГ Бүх сумд	2010-2016
22	<ul style="list-style-type: none"> <li>• Өндөр хүчин чадалтай олон удаагийн үйлдлийг нэг явалтаар гүйцэтгэдэг орчин үеийн техникийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;</li> </ul>	Аймгийн ХХААЖДҮГ	2009-2016

23	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөө аж ахуйг харилцан бие биенээ тэтгэсэн бүтэц бүхий хөдөө аж ахуй, үйлдвэрийн цогцолбор болгон хөгжүүлэх;</li> </ul>	Аймгийн ХХААЖДҮГ	2009-2016
24	<ul style="list-style-type: none"> <li>• Малчдын түлш, эрчим хүчний хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх .</li> </ul>	Аймгийн ХХААЖДҮГ “ДБЭХС” ХК	2009-2016

**б/ Бусад салбарын үйлдвэрлэлт**

Үйлдвэрүүдийн нэр	Хэрэгжүүлэх газар, байгууллага	Хугацаа
<b>1.Уул уурхайн болон хүнд үйлдвэр</b> 1. Металл гулдмай 2.Баяжмал хийх үйлдвэр 3. Ураны үйлдвэр 4.Нүүрсолборлох, коксжсон нүүрс 5. Утаагүй түлшний үйлдвэр	Шин-Шинь ХХК Шан лун ХХК Эмээлт майнз ХХК Төв Азийн Уран ХХК Адуунчулуун ХК Талын жигүүр ХХК	2010-2016 он
<b>2.Төмөр хийцийн үйлдвэр</b> 1. Хадаас 2.ган цувимал 3.угольник 4.дээврийн төмөр 5.Металл хайлшний / тогоо, ган бөмбөлөг/	Хэрлэн	2011-2016
<b>3.Нефть боловсруулах үйлдвэр</b> 1. Шингэн түлш 2..Шатдаг түлш	Матад сум	2013-2016

<p><b>4.Барилгын материалын үйлдвэр</b></p> <p>1.Шилний үйлдвэр  2.Шилэн пильта  3.өнгөт хавтан,шахмалын үйлдвэр  4.Хөөсөнцэр, дүүргэгчийн үйлдвэр  5.Байшин үйлдвэрлэх комбинат  6.Шохойн үйлдвэрлэл  7.Тоосгоны үйлдвэр  8.Тулгуур шонгийн үйлдвэр  9.Шахмал модон шал  10. Асфальто бетоны үйлдвэр  11. Вакум цонхны үйлдвэр</p>	<p>Хэрлэн Халхгол</p>	<p>2011-2014</p>
<p><b>5.Хүнсний үйлдвэрүүд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр үүнд:</li> <li>• сүү бэлтгэх , хуримтлуулах үйлдвэр</li> <li>• Бяслагны үйлдвэр</li> <li>• Цэцгийний</li> <li>• Хуурай сүүний үйлдвэр</li> <li>• Тарагны</li> </ul>	<p>Хэрлэн Булган Баян-Уул Баянтүмэн Сэргэлэн</p>	<p>2009-2016</p>
<p><b>6.Мах, махан бүтээгдэхүүн</b></p> <p>1.Бэлтгэх  2. Боловсруулах /консерв, хиам/  3.Экспортлох  4.Пакеталсан, хагас боловсруулсан бууз, банш, жигнэсэн, шарсан мах</p>	<p>Сэргэлэн Дашбалбар Хэрлэн Халхгол Гурванзагал Баяндун</p>	<p>2010-2016</p>
<p><b>7.Хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэр</b></p> <p>Даршлах  Савлах  Варень хийх  Тетрапах савлагаатай жүүс бэлтгэх</p>	<p>Хэрлэн Халхгол Баян-Уул Чулуунхороот</p>	<p>2010-2016</p>
<p><b>8.Ургамлын тос бэлтгэх</b></p>	<p>Халхгол</p>	<p>2010-2013</p>
<p><b>9.Зөгийн бал савлах</b></p>	<p>Дорнод бүсийн эрдэм шинжилгээ</p>	<p>2010-2011</p>

	Үйлдвэрлэлийн төв	
<b>10.Спиртын үйлдвэр</b>	Хэрлэн сум	2010-2012
<b>11.Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр, цехүүд</b>	Бүх сумд	2009-2011
<b>12.Ноос угаах үйлдвэр</b> Эсгий бүрээс, туурга, ширдэг, эсгий гутал	Хэрлэн Хөлөнбуйр	2010-2011
<b>13.Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр</b> Бэлэн хувцас Хөнжил	Хэрлэн	2010-2016
<b>14.Савхи, ширэн бүтээгдэхүүний үйлдвэр –</b> Бэлэг дурсгалын зүйлийн үйлдвэр, Цүнхний үйлдвэр	Хэрлэн	2011-2012
<b>15.</b> Бетонон хийц эдлэлийн чанарын баталгаа олгох бүсийн лаборатори	Хэрлэн	2010
<b>16.</b> Хилийн боомтуудад металл сорьцын баталгаа тогтоох лаборатори	Хэрлэн	2011
<b>17.</b> Нефть шингэн түлшний хэмжээг тодорхойлох лаборатори	Хэрлэн	2012
<b>18.Үндэсний ардын уламжлалт бүтээгдэхүүний үйлдвэр</b> Буриад, монгол гутал Эмээл, хазаар, тохом,сур, тохош, үндэсний хувцасны үйлдвэр	Цагаан-Овоо Дашбалбар Баян-Уул Хөлөнбуйр Хэрлэн	2011-2016
<b>19.Алт, мөнгө, зэсээр гоёлын зүйлс үйлдвэрлэх</b>	Хэрлэн	2011
<b>20.Ахуй үйлчилгээний төв</b>	Бүх суманд	2010-2016
<b>21.Монгол гэрийн үйлдвэр Боловсронгуй болгосон монгол гэр, сууц үйлдвэрлэх, модон эдлэл, гэрийн тавилга,</b>	Баян-Уул Хэрлэн	2011-2014
<b>22.Байгалийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэр</b> Цэвэр ус, рашаан савлах, загас консервлох,, давсны үйлдвэр, давсны шахмал хийж экспортлох, шүү, хужир, мангир, таана, арц, хүж	Хэрлэн Баяндун Чойбалсан Дашбалбар	2010-2016

Ардын уламжлал эмнэлгийн эм, Гоо сайхны бүтээгдэхүүн саван, оо,шампунь	Халхгол Матад Баян-Уул	
<b>23.Шинжлэх ухаан технологийн парк байгуулах,</b> өндөр технологи ашиглан нарийн технологи шаардагдах бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох, дэлхийн нэртэй компаниудын бүтээгдэхүүнүүдийн деталл хийх, угсрах үйлдвэр байгуулах	Хэрлэн сум	2015-2016
<b>24.Жижиг нисэх онгоц угсрах үйлдвэр</b>	Хэрлэн сум	2015-2016
<b>25. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр</b> / ДЦС-ыг түшиглэн хог шатаах зориулалттай Перолизын зуух төсөл хэрэгжүүлэх/ ОО-ийн цаас, ясны гурил, савангийн үйлдвэр	Хэрлэн сум	2011-2013

## 2.3 ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

### 2. 3.1 Зам, тээврийн хөгжийн бодлого

**Нэгдүгээр үе шат (2009-2016 он):**

**Стратегийн зорилт 1. Аймгийн авто замын сүлжээг сайжруулж зарим замыг хатуу хучилттай болгоно:**

- Автозамын салбарыг хөгжүүлэхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг бүх талаар урамшуулан дэмжих;
- Аймгийн авто замын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;
- Зам, гүүрийн барилгын техник хэрэгслийн хангамжийг урт хугацааны бага хүүтэй зээл (лизинг)-д хамруулах;
- Нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн паркийн 80 хувийг шинэчлэх;
- Тээвэрлэгч аж ахуй нэгж байгууллагын үйлчилгээг төрөл, хүчин чадал, үйл ажиллагааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх; Чойбалсан-Хайлаар-Харбин, Чойбалсан-Чита чиглэлийн олон улсын агаарын нислэг үйлдэх,

- Чойбалсан-Архашаат хилийн боомт чиглэлийн 140 км хатуу хучилттай автозамыг барих
- Чойбалсан-Тамсаг-Өвдөг-Баянхошуу, Тамсаг-Бичигт зэрэг чиглэлийн хатуу хучилттай замуудыг барих
- Сумдын төвүүдтэй хатуу хучилттай замаар холбогдох судалгааны ажлыг эхлүүлэх
- Өндөрхаан-Чойбалсан-Сүмбэр-Рашаант, /Мянганы замын хэвтээ тэнхлэг/
- Эрээнцав-Чойбалсан-Баруун-Урт-Бичигт, Ульхан-Чойбалсан-Баруун-Урт /Мянганы замын босоо тэнхлэг/ чиглэлийн замыг улсын төсвийн хөрөнгөөр барих
- Чойбалсан – Сүмбэр –Рашаант, Сайншанд – Баруун Урт- Чойбалсан, Бичигт – Хөөт -Чойбалсан чиглэлийн төмөр замыг барих ажлын судалгааг хийх

### **2.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг жилд дунджаар 5.2 хувиар өсгөж өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадвартай, хөрш зэргэлдээ орнуудад эрчим хүч экспортолно.**

- Өндөр хүчдлийн шугамын дагуу томоохон суурин газар багийн төвийг төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрт холбох,
- Төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрээс алслагдсан багийн төв, эрчимжсэн аж ахуйг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах
- Бага нуур - Чойбалсангийн 220 Кв-ын өндөр хүчдэлийн шугамыг ашиглалтанд оруулах
- Чойбалсан хотын дулааны цахилгаан станцад өргөтгөл хийж 100 МВт хүчин чадалтай үйлдвэр байгуулах
- Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолсны үндсэн дээр эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж сумдыг нэгдсэн халаалтын системтэй болгох шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, техникийн шинэчлэл хийх;
- Захын гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах, өргөтгөх, нэмэлт цахилгаан дамжуулах шугам татах;
- Зүүн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний дэд станцуудын суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх, шаардлагатай техник тоног төхөөрөмжийг шинэчлэх;
- Хөдөөгийн малчин айл өрхийг 100 хувь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх;
- Ашигт малтмалын орд газрыг түшиглэн атомын цахилгаан станц байгуулан цахилгаан эрчим хүчийг хөрш зэргэлдээ орнуудад экспортлох,судалгааны ажлыг дуусгах

### **2.3. 3 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого**

***Стратегийн зорилт 1. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээг шинэчлэх замаар “Мэдээлэлжсэн нийгэм”-ийг байгуулах суурь үндсийг бүрдүүлж, бүрэн утгаар нь байгуулна:***

- “Цахим Монгол” хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг аймаг, сумдад бүрэн хэрэгжүүлэх;
- Хэвлэлийг электрон хэлбэрээр хүргэж, хэвлэх ажлыг зохион байгуулах;
- Сумдыг 2010 оноос эхлэн шилэн кабелиар холбож төрийн болон арилжааны цахим үйлчилгээг хүлээн авах боломжийг хөдөөгийн хүн амд хүргэх
- Аймгийн хэмжээнд бүх нийтийн компьютержүүлэлт, өрх бүрт интернет дэд хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх;
- Бүх сумдын төвд интернет цэг, интернет кафе байгуулж, үйлчлэх;
- Бүх сумдад 10-оос доошгүй сувгийн телевизийн нэвтрүүлэг үзэх боломж нөхцлийг бүрдүүлэх;
- Орон нутгийн телестудийг аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан мэргэжлийн телевиз болгон хөгжүүлэх;
- Бүх сумдын төвд утасгүй холбоо, үүрэн телефон, интернетийн үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх;
- Шуудан холбооны сүлжээг ашиглан орчин үеийн шинэ төрлийн электрон үйлчилгээ болон хэрэглээ нэвтрүүлэх, сумын багийн шуудан хүргэлтийн давтамжийг 2 дахин нэмэгдүүлэх;
- Нутгийн төр, захиргааны байгууллагыг нэгдсэн сүлжээнд холбож, электрон засаглал, мэдээллийн сан бүрдүүлэх;

### **2.4. ЗҮҮН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ ЧОЙБАЛСАН ХОТЫГ ХӨГЖҮҮЛЭХ**

***Стратегийн зорилт 1. Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимтэй хөгжүүлнэ:***

- Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийх
- Хотын суурьшсан бүсийн газар ашиглалтын өнөөгийн байдлыг сайжруулан орчин үеийн хот байгуулалт, экологийн шаардлагад нийцсэн газар ашиглалтыг шинэчлэн зохион байгуулах төсөл боловсруулан хэрэгжүүлэх
- Чойбалсан хотийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцийг өргөтгөн тэлж сайжруулах,
- Олон улсын тэмцээн, уралдаан зохион явуулах арван мянган хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулах
- Хүүхдийн парк байгуулах,
- Эр хүний овоонд алсыг харагч дуран байрлуулан, хотоо сурталчилах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон тохижуулах
- Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнг амралт чөлөөт цагийн цогцолбор болгон өргөжүүлэх,

- Хөл бөмбөг, хоккей, гольфийн талбай, усан сан, бассейн, боулинг, морин тойруулгын уралдааны газар байгуулах
- Орон сууцнуудын дундах талбайг иж бүрэн тохижуулах
- 
- Орон сууцны хангамжийг сайжруулан худалдаа, үйлчилгээний төв, машины граж бүхий 9 давхар орон сууцны хотхоныг барих
  - Шинээр баригдах барилга байгууламжийн доорхи подвалийг авто машины дулаан зогсоол /граж/-аар тохижуулах, ил гражгүй болох,
  - Боловсронгуй болгосон монгол гэр, сууцаар хангах байдлаар орон гэргүй айл өрхгүй болгох,
  - Хэрлэн голын дагуу зуслангийн газар олгож, зуслангийн байшин барих
  - Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын томоохон хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд газар олгож, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэхүйц орчин үеийн хийц загвар бүхий оффис бариулах,
  - Олон улсын худалдаа бараа солилцоо гаалийн баталгаат агуулахын бүсийг Чойбалсан хотод бий болгох ажлыг эхлүүлнэ.
  - Хотын төв зам, Залуус талбай, орон сууцны дунд, албан байгууллагын орчины цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх
  - Таван давхар байрнуудыг мансардтай болгох замаар орон сууцны тоог нэмэгдүүлнэ.
  - Аймагын Засаг даргын Тамгын газрын байрны өмнөх талбайд усан оргилуур, мэдээлэл сурталчилгааны зориулалттай өргөн дэлгэц бүхий гадна талбайн электрон самбар байрлуулах,
  - Монгол үндэсний баяр наадмын түрүү морь, бөх, сурын спортын алдрын ордон, танхимтай болгох, гэрлэх ёслолын ордон байгуулах,
  - Хэрлэн голын эргийг нуралтаас хамгаалан эргийн хамгаалалт болон үерийн далан байгуулах,
  - Худалдааны төв, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд дулаан, цэвэр бохир усанд холбосон бие засах газрыг 10-аас доошгүйг байгуулах
  - Чойбалсан хотын хатуу хучилттай төв, туслах замыг шинэчлэн сайжруулах, гэрэлтүүлэг, явган зам, ногоон байгууламж бүхий цогц байдлыг хангах
  - Хотын нийтийн тээврийн хэрэгцээнд бүрэн тохижуулсан 2-оос доошгүй автобус гарган, төв ба хойд засмал замаар, цагийн хуваарын дагуу маршрутаар үйлчлэх,
  - Газар олголтын асуудлыг цэгцэлж, гэр хорооллын гудамж талбайг эмх замбараатай болгох, дэд бүтэц, зам барилгын сүлжээнд холбох,
  - Хотын цэцэрлэгжүүлэлтийн генплан боловсруулж хэрэгжүүлэх
  - Аймаг, хотын түүхэн холбогдолтой барилга байгууламжийг тохижуулж, түүхийн ул мөрийн гэрч болгон хадгалах
  - Бүсийн төвийн хувьд өвөрмөц нутгийн захиргааны ордонтой болох

## 2.5. ГАДААД ХАРИЛЦААГ ХӨГЖҮҮЛЭХ

*Дорнод аймгийн хөгжлийн 5 дахь тэргүүлэх чиглэлийн хүрээнд гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж аймгийн эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.*

Стратегийн зорилт 1 Харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

- Аймгийн гадаад харилцааг өргөжүүлэн нэг цонхны бодлого баримтлах хүрээнд бүс нутгийн гадаад харилцааны бие даасан байгууллага бий болгох,
  - Хөрш зэргэлдээ орших ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар, БНХАУ-ын Хөлөнбуйр хот, Хянган аймаг, Шилийн гол аймагтай уламжлалт харилцааг өргөжүүлнэ.
  - Өндөр хөгжилтэй орон АНУ-ын Арлингтон хот, БНХАУ-ын Хунань, Хубие муж, Япон, БНСУ, БНЭУ, Тайланд улстай цахим тоцоолол, мэдээлэл технологи, ХАА, жижиг дунд үйлдвэр, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр хамтарч ажиллах,
  - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаар хотод Монголын консулын төлөөлөгчийн газрыг 2010 онд байгуулах
  - Хятадын талын хөрөнгө оруулалтаар Хавирга хилийн боомтоос Чойбалсан сумын төв хүртэл 80 км –т хатуу хучилттай зам барих,
  - Тамсагаас – Баянхошууны боомт хүртэл 200 км хатуу хучилттай замыг гадаадын хөрөнгө оруулалтаар барих
  - Монгол улс, БНХАУ-ын хооронд байгуулсан тээврийн хэлэлцээрийн холбогдох заалтад өөрчлөлт оруулах замаар албан байгууллага, бизнес эрхлэгчдийн хэрэглэж буй гуравдагч орны авто машиныг орон нутгийн чанартай боомтуудаар саадгүй нэвтрүүлдэг болох
  - Монголын зүүн бүс нутагт Европ Азийг холбосон далайд гарах хувилбар болох БНХАУ-ын Жэнжоү-Фусин-Зүүн хатавч чиглэлийн төмөр замыг Бичигтийн боомт-Баруун урт-Чойбалсан чиглэлээр байгуулж, Хятадын хөрөнгө оруулалттай төмөр замын биеэ даасан байгууллага байгуулах,
- 
- Сүмбэр – Рашаантын боомтыг түшиглэн Халхголын районд гадаад дотоодын жуулчид, сонирхогчдын хөрөнгийг орон нутгийн хөгжилд оруулах зорилго бүхий холбогдох хууль, стандартад нийцэхүйц мөрийтэй тоглоомын газар /казино/ байгуулах
  - Сүмбэр-Рашаантын олон улсын чанартай боомтыг нээн ажиллуулах, Эрээнцав – Соловьевск, Хавирга- Ар хашаатын боомтуудын дэд бүтцийг сайжруулж, хил дамнасан аялал жуулчлалын сүлжээ бий болгон хөнгөвчилсэн нөхцөлөөр хил нэвтрэх асуудлыг шийдэх, Орос, Монгол, Хятад 3 улсын хил орчмын аймаг, бүс нутагт худалдаа арилжаа, эдийн засгийн чөлөөт бүс нээж, аялал жуулчлалын бүстэй холбож өгөх,
  - Чойбалсан – Тамсаг – Сүмбэрийн чиглэлээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймгийн Рашаан хоттой төмөр замаар холбогдох,
  - Хайлаар – Харбин - Чита хотуудтай агаарын зам нээж олон улсын нислэг үйлдэх
  - Аймаг, бүсийн үйлдвэрүүдийн брэнд бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд таниулах зорилгоор олон улсын үзэсгэлэн, яармаг худалдаанд оролцох, зохион байгуулах
  - Зүүн хойд Азийн улс орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, Эмэгтэйчүүд, хүүхдийн төрийн бус байгууллагын салбар хороог аймагтаа байгуулах
  - Экспортын баримжаатай экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх загвар аж ахуй, жижиг дунд үйлдвэр, фермерийн аж ахуй байгуулахад гадаадын хөрөнгө оруулалт, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, нутагшуулах

- Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, спортын чиглэлээр оюутан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, туршлага судлах, урлаг спортын олон улсын арга хэмжээг зохион байгуулах, гадаад оронд болох үйл ажиллагаанд идэвхитэй оролцох,

## 2.6. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ

**Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 13.9 хувьд, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлд аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жинг 63.6 хувьд хүргэж аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно:**

- Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Аймгийн аялал жуулчлалын маршрутыг Зүүн бүсийн маршруттай холбон бүсийн аялал жуулчлалыг тууштай хөгжүүлэх; / Хэнтийн Онон, Балж, Сүхбаатарын Дарьганга, Дорнодын Халхгол/
  - Аялал жуулчлалын цогцолбор, бааз байгуулах төслүүдийг боловсруулж, хөрөнгө оруулагчдад санал болгох;
  - Аялал жуулчлалын гол бүс Хэрлэн, Халхгол суманд дотоод, гадаадын жуулчдыг хүлээн авах, олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчдын бааз байгуулах,
  - Аяллын тогтоосон маршрутын дагуух авто замыг засварлаж, тэмдэгжүүлэх, түр буудаллах дэн буудлын нэгдсэн сүлжээ байгуулахыг дэмжих,
  - Жуулчдын баазын ойролцоо угсаатны зүйн болон бусад зан үйлийг сонирхуулах, эмнэг мал сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, морин аялал хийх, үзэсгэлэн гаргаж үзүүлэх зэрэг арга хэмжээг өргөн зохион байгуулах, энэ чиглэлээр сурталчилгаа явуулах;
  - Одоо ажиллаж байгаа жуулчдын бааз, амралт, сувилалын газруудыг тохижуулж, музейн үзмэрүүдийг баяжуулах арга хэмжээ авах;
  - Аялал жуулчлалын анхан шатны менежмент болон хөтөч, гадаад хэлний сургалтууд зохион явуулах;
  - Аялал жуулчлалын маршрутын дагуух түүх соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах ажлыг идэвхжүүлэх;
  - Зочид буудал, зоогийн газар зэрэг үйлчилгээний газруудыг өргөтгөн тохижуулан зэрэглэл тогтоож, орчин үеийн стандартад нийцүүлэх;
  - Аялал жуулчлалын отог, баазуудын менежментийг сайжруулах зорилгоор ажиллагсдыг нь төрөлжсөн сургалтад хамруулах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх;
  - Жуулчдын бааз, амралт сувиллын газруудыг нэмэгдүүлэх, аймаг орон нутгийн удирдлагатай нягт хамтран ажиллах нөхцөл бүрдүүлэх;
  - Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, худалдаа, уулзалтуудыг зохион байгуулах

### ГУРАВ. ДОРНОД АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Д/д	Үзүүлэлтүүд	2000	2008	2016 /төсөөлөл/
1	Суурин хүн ам	73912	74514	78011

	Үүнээс Эрэгтэй	36091	36579	38225
	Эмэгтэй	37821	37935	39786
<b>2</b>	Эдийн засгийн идэвхитэй хүн ам	19093	22982	27300
	Үүнээс: ажиллагчид	16696	22065	26880
	Бүртгэлтэй ажилгүйчүүд	2397	917	420
<b>3</b>	Төрөлт	1483	1769	2200
<b>4</b>	Нас баралт	574	486	
<b>5</b>	Дундаж наслалт	58	63	68
<b>6</b>	Өрхийн тоо	17265	19886	22500
<b>7</b>	ДНБ /оны үнээр/ сая төг./	16461.5	79987.0	239961.0
	Нэг хүнд ногдох ДНБ /мян. төг./	222.8	1073.4	3500.0
<b>8</b>	Малын тоо /мян. төг/	826	1476.2	2116.0
<b>9</b>	Малчин өрхийн тоо	4908	4719	5400
<b>10</b>	Тариалсан талбай /га/	5144	2781.8	25000.0
<b>11</b>	Хураасан ургац	2028	5573.8	50100.0
<b>12.</b>	Авто машины тоо	1457	3287	4800
<b>13</b>	Үүрэн телефон хэрэглэгчийн тоо	-	38800	41000
<b>14</b>	ЕБС-ийн тоо	25	26	28
<b>15</b>	ЕБС-д суралцагсадын тоо	16582	15008	16000
<b>16</b>	Цэцэрлэгийн тоо	24	23	25
<b>17</b>	Цэцэрлэгийн хүүхдийн тоо мян.	2.5	3.5	5.0
<b>18</b>	10000 хүнд ногдох их эмчийн тоо	18.8	17.8	18.4

## **ДӨРӨВ. ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ**

### **4.1. Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн**

Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлснээр дараахь томоохон үр дүнд хүрнэ:

**Эхний үе шат (2009-2016 он)**-ны эцэст бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, аймгийн эдийн засгийн бүтцэд аж үйлдвэрийн эзлэх байр суурь дээшилж, үйлдвэрлэл технологийн парк байгуулагдан, **ДНБ-ний жилийн дундаж өсөлт 9.1 хувиас доошгүй** өснө. ДНБ-ний 43.3 хувийг аж үйлдвэр барилгын салбарт, 23.7 хувийг ХАА-н салбарт, 33.0 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ. Мөн аж үйлдвэрийн салбарын ДНБ-ний 54.4 хувийг боловсруулах салбарт үйлдвэрлэж, экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэл бий болно.

Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ энэ үе шатанд жилд дунджаар 9.6 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ний 42.3 хувийг үйлдвэрлэх болно. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан ХАА-н салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 10.6 хувиар өснө. Мөн аймгийн хэмжээнд ядуурал, ажилгүйдлийг бууруулж, ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлж, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл болон нялхсын эндэгдлийн түвшинг бууруулна.

#### **4.2. Цогц бодлогын хэрэгжилтийг хангах механизм**

Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлогыг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрүүд болон энэ баримт бичгийн хүрээнд боловруулах дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөө, төслүүдэд тусган хэрэгжүүлнэ.

Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлогын жил бүрийн хэрэгжилтийг Засаг дарга дараа жилийн эхний улиралд багтаан Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэн дүгнэх ажлыг дараахь байдлаар зохион байгуулна.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэн дүгнэх үе шатууд:

**Эхний үе шат:** Бодлогын зорилтын эхний шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр);

Хяналт, шинжилгээ, үнэлгээг аймгийн төрийн захиргааны байгууллага холбогдох мэргэжлийн болон судалгааны, түүнчлэн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор нэгдсэн төлөвлөгөөний үндсэн дээр хийх бөгөөд зохих зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Хяналт, шинжилгээ тасралтгүй явагдана.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт бүрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт байх бөгөөд гол анхаарал хандуулах зарим зорилтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг салбар тус бүрээр урьдчилан тодорхойлсон байна.

### **ТАВ. ДОРНОД АЙМГИЙН СУМДЫГ 2009-2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД, СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Стратегийн зорилт 2 Сум бүр өөрсдийн давуу тал, онцлогыг тусгасан хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

- Сумын төвүүдэд хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх талбай, цэцэрлэгийг тохижуулах
- Орон нутгийг судлах музейн үзмэрийг шинэчлэх, соёлын төвийг зориулалтын дагуу үйл ажиллагааг нь тогтмолжуулах
- Сумд газар зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
- Сумдад богино долгионы FM радионы суваг нээх
- **Баян-Уул** суманд Онон Балжийн байгалийн нөөц газрыг түшиглэн аялал жуулчлалын бааз, Эрээний модны үйлдвэрийн суурин дээр гэр ахуйн мод, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл байгуулах, жимс, жимсгэнэ тариалан нөөцлөх, савлах,
- **Халхгол** суманд үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, загас консервлох үйлдвэр, зөгийн аж ахуй, Буйр нуур, Нөмрөгийн дархан цаазат газрыг түшиглэн аялал жуулчлалын иж бүрэн цогцолбор байгуулах, малын тэжээл, хадлан бэлтгэн экспортлох,
- **Баяндун** суманд “Наран” булаг, Могойтын рашааныг түшиглэн рашаан, цэвэр усны үйлдвэр, хүнсний ногоо тариалах, арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийх, сүү, цагаан идээний үйлдвэр байгуулах
- **Цагаан-Овоо** суманд үр тариа, хүнсний ногоо, малын тэжээл тариалах, үйлдвэрийн аргаар хорголжин, багсармал тэжээл бэлтгэх, төл, малын арьс элдэх, анхан шатны боловсруулалт хийх, Гүн цэнгэлгийн амралтыг өргөтгөх
- **Хөлөнбуйр** суманд барга омгийн хонийг үүлдэр болгож, шилмэл үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгч худалдах, хонины ноос угаах, эсгий, эсгий гутлын үйлдвэр байгуулах, үр тариа тариалах,
- **Булган** суманд сүү, цагаан идээний үйлдвэр, Тугийн сүмийг түшиглэн аялал жуулчлалын бааз байгуулах,
- **Дашбалбар** суманд Чухын амралтын газрыг түшиглэн амралтын газар, Цагаан хөндийн рашааныг савлах, махны жижиг үйлдвэр, малын түүхий эд боловсруулах цех ажиллуулах
- **Баянтүмэн** суманд фермерийн аж ахуй, төмс, хүнсний ногоо тариалах, барилгын түүхий тоосго үйлдвэрлэх, хүүхэд, насанд хүрэгчдын амралтын газар байгуулах, өргөжүүлэх
- **Чулуунхороот** суманд Монгол дагуурын тусгай хамгаалалттай газрыг түшиглэн байгалийн аялал жуулчлалын бааз, хүлэмжийн аж ахуйгаар өргөст хэмх, улаан лооль тариалан боловсруулалт хийж савлах, талх, нарийн боовны цех, гахай, тахиа үржүүлэх,
- **Сэргэлэн суманд** үзэмчин омгийн хонийг үржүүлэхийн зэрэгцээ саалийн үхэр, гахай үржүүлэн мах сүүгээр аймгийн төв, суурин газрын хэрэгцээг хангах фермерийн аж ахуй хөгжүүлэх,
- **Матад суманд** хурдан удмын адуу, давхар зогдорт тэмээг өсгөн үржүүлж, Хөөтийн нүүрсийг түшиглэн шахмал түлшний үйлдвэр байгуулах,
- **Чойбалсан суманд** Утаат Минжүүрийн рашааныг түшиглэн рашаан сувилалын газар байгуулах, тахианы ферм ажиллуулж, үр тариа тариалан, хадлан тэжээл бэлтгэх
- **Гурванзагал суманд** байгалийн хадлан бэлтгэх, Манлай ван Дамдинсүрэнгийн хөшөө музейг өргөтгөн ахмад үеийн дайчин уламжлалаас суралцах төв байгуулах

\_\_\_\_\_о О о\_\_\_\_\_

## АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС